

Чулуурч хувь



БАТЛАВ

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Р.БАТСҮХ



БАТЛАВ

"ПИ СИ ДИ ПИ" ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.ПУНЦАГНОРОВ

**ТӨМӨР ЗАМЫН ТӨМӨР БЕТОН УГСАРМАЛ ХООЛОЙН  
НЭГ МАЯГИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2019 оны 11 дүгээр  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот  
Дугаар АТТ-19/267236/104

**1. Нийтлэг үндэслэл**

1.1. Төмөр замын төмөр бетон угсармал хоолойн нэг маягийн зураг төсөл боловсруулах ажил гүйцэтгэх гэрээг (цаашид "Гэрээ" гэх)

**Нэг талаас:** "МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК (цаашид "Захиалагч" гэх),

**Нөгөө талаас:** "ПИ СИ ДИ ПИ" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх), (цаашид хамтад нь "Талууд" гэх) нар Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Гүйцэтгэгч энэхүү гэрээгээр төмөр бетон угсармал хоолойн нэг маягийн зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулах, Захиалагчид хүлээлгэн өгөх, Захиалагч нь тохиролцсон ажлын хөлсийг төлөхтэй холбоотой үүсэх харилцаанд талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж зохицуулна.

1.3. Захиалагч нь төмөр бетон угсармал хоолойн нэг маягийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг Гүйцэтгэгчид гаргаж өгөх бөгөөд энэхүү гэрээний хавсралт болно.

1.4. Энэхүү гэрээ нь энэ гэрээ болон түүний хавсралтуудаас бүрдэнэ. Гэрээ, түүний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

**2. Гэрээний зүйл**

2.1. Энэхүү гэрээний зүйл нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 1.5 метр дугуй, 1.5\*1.5 метр дөрвөлжин, 2\*2 метр дөрвөлжин, 3\*3 метрийн дөрвөлжин төмөр бетон угсармал хоолойн нэг маягийн зураг төслийг хууль тогтоомж, стандарт, ажлын даалгаврын дагуу боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажуулах ажил байна.

**3. Баталгаа**

3.1. Захиалагч нь гэрээний дагуу ажил гүйцэтгүүлэх захиалга өгөх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай эрхийг эрх бүхий байгууллагаас авсан гэдгийг үүгээр баталж байна.



3.2. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ажил гүйцэтгэх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, тэдгээр нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх боловсон хүчний болон санхүүгийн бүрэн чадамжтай гэдгийг үүгээр баталж байна.

3.3. Гүйцэтгэгч нь ажлыг хууль тогтоомж болон энэ гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн, эрхийн болон биет байдлын доголдолгүй, холбогдох бичиг баримт нь үнэн зөв, бүрэн гүйцэд хүлээлгэж өгнө гэдгийг үүгээр баталж байна.

3.4. Талууд энэхүү Гэрээг байгуулахтай холбогдуулан мэдсэн нөгөө талын үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээллийг тухайн талын зөвшөөрөлгүйгээр хууль болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй, энэхүү гэрээнээс үүссэн харилцаанаас өөр бусад зорилгоор ашиглахгүй байхыг үүгээр баталж байна.

#### **4. Хууль тогтоомж, гэрээг тайлбарлах**

4.1. Талууд Гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэн, эрх бүхий байгууллагаас баталсан аливаа дүрэм, журам, заавар, стандарт, шаардлагад нийцүүлэн талуудын хоорондын эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан байгуулав.

4.2. Гэрээний зүйл заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд хэрэв энэ гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хууль, тогтоомжид заасныг баримтална.

#### **5. Гэрээг байгуулсанд тооцох**

5.1. Гэрээнд талуудын төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

5.2. Гэрээг монгол хэлээр хоёр хувь үйлдэж, Гүйцэтгэгч, Захиалагч тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.

5.3. Талууд гэрээг бүртгүүлэх, батлуулах шаардлагатай тохиолдолд түүнтэй холбоотойгоор холбогдох бүхий л баримт бичиг, мэдээллийг гарган өгч хамтран ажиллана.

#### **6. Гүйцэтгэх ажлын үр дүн**

6.1. Гэрээний 2.1-д заасан ажлыг гүйцэтгэсний үр дүнд Захиалагч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан, ажлын даалгаварт заагдсан иж бүрдэл бүхий төмөр замын 1.5 метр дугуй, 1.5\*1.5 метр дөрвөлжин, 2\*2 метр дөрвөлжин, 3\*3 метрийн дөрвөлжин төмөр бетон угсармал хоолойн нэг маягийн зураг төсөлтэй болсон байна.

6.2. Ажлын гүйцэтгэл нь хууль тогтоомж, дүрэм, заавар, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байх бөгөөд эрх бүхий төрийн байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

6.3. Ажлын үр дүн захиалагчийн өмчид тооцогдоно.

#### **7. Ажил гүйцэтгэх хугацаа**

7.1. Гүйцэтгэгч нь төмөр бетон угсармал хоолойн нэг маягийн зураг төсөл боловсруулах ажлыг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 10 хоногийн дотор хийж дуусгах бөгөөд

бэлэн болсон зураг төслийг эрх бүхий байгууллагаар 14 хоногийн дотор баталгаажуулан, Захиалагчид хүлээлгэн өгнө.

7.2. Давагдашгүй хүчин зүйлээс бусад тухайлбал, ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, ажил гүйцэтгэхэд шаардагдах техник тоног төхөөрөмжид гарсан аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг зөрчих буюу хойшлуулах үндэслэл болохгүй.

7.3. Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь ажил гүйцэтгэгчид захиалагчийн зүгээс энэ гэрээнд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

## **8. Ажлын гүйцэтгэлд хяналт тавих**

8.1. Ажлын гүйцэтгэлд Захиалагчийн зүгээс "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Инженер, технологийн хэлтэс хяналт тавина.

8.2. Ажлын гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор Захиалагч болон түүний ажилтан нь дараах эрх эдэлнэ:

8.2.1. ажлын явцыг шалгах, дүрс бичлэг болон фото зургаар баримтжуулах;

8.2.2. хөндлөнгийн шинжээч урьж ажиллуулах, дүгнэлт гаргуулах;

8.2.3. шаардлагатай тайлбар, мэдээлэл, баримт бичгийг ажил гүйцэтгэгчээс гаргуулан авах.

8.3. Ажлын гүйцэтгэлийн явцыг шалгаж баталгаажуулахдаа талууд хамтарсан тэмдэглэл үйлдэн, ийнхүү шалгасан эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зуран баталгаажуулна.

8.4. Ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр ажил гүйцэтгэх нарийвчилсан хуваарийг гарган мөрдүүлж болно.

## **9. Ажлын доголдлыг арилгах, гомдлын шаардлага гаргах**

9.1. Гүйцэтгэгч нь ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, эсхүл хууль тогтоомж, захиалагчийн өгсөн ажлын даалгавар болон төрийн эрх бүхий хяналтын байгууллагын бичгээр өгсөн чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн, зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон энэ гэрээний гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг өөрийн хөрөнгөөр засаж доголдлыг арилгах, үүнээс үүсэн захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

9.2. Гүйцэтгэгч ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан шууд болон шууд бус хохирлыг бүрэн хариуцна.

9.3. Гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш гурван жилийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

## **10. Мэдээлэл солилцох, мэдээллээр хангах**

10.1. Талуудын албан ёсны хаяг:

10.1.1. Захиалагч: "Монголын төмөр зам" Төрийн өмчит хувьцаат компани

Улсын бүртгэлийн дугаар: 9012001025

Регистрийн дугаар: 5214203

Хаяг: Юнион бюлдинг, А блок, 7 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол, Нарны зам-62, Улаанбаатар /14230/

Утас: 7000-6622, 7010-6655

Имэйл: [info@mtz.mn](mailto:info@mtz.mn)

10.1.2. Гүйцэтгэгч: “Пи Си Ди Пи” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011392005

Регистрийн дугаар: 5669995

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: ЗТ 18-1001/17

Албан ёсны хаяг: Санроуд барилга, 5 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 91, Улаанбаатар /14230/

Утасны дугаар: +976 77117196

Факсын дугаар: +976 77117195

И-мэйл: [admin@pcdp.mn](mailto:admin@pcdp.mn)

- 10.2. Гэрээний талууд үйл ажиллагаа эрхлэн явуулахад шаардлагатай мэдээллийг харилцан солилцож байна.
- 10.3. Мэдээллийг бичгээр болон факс, и-мэйл зэрэг цахим хэлбэрээр солилцоно.
- 10.4. Хойшлуулшгүй тохиолдолд талууд мэдээллээ амаар болон утсаар солилцож болох боловч ийнхүү солилцсон мэдээллээ баталгаажуулж, 24 цагийн дотор нөгөө талд хүргүүлнэ.
- 10.5. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ баримт, судалгаа, зааварчилгааг ажил гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу боломжит хугацаанд гаргаж өгнө.

**11. Ажлын гүйцэтгэлийг хүлээлцэх**

- 11.1. Талууд ажлын гүйцэтгэлийг тал тус бүрээс 2-оос доошгүй ажилтан оролцуулж, акт үйлдэн хүлээлцэнэ.

**12. Ажлын хөлс**

- 12.1. Энэхүү гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх хөлс нь 19,533,681 (арван есөн сая таван зуун гучин гурван мянга зургаан зуун наян нэг) төгрөг бөгөөд энэхүү үнэ гэрээний хугацаанд тогтвортой байна.
- 12.2. Ажлын хөлсөнд холбогдох татвар, хураамж /НӨАТ, аж ахуйн нэгжийн орлогын гэх мэт/, шаардлагатай стандарт, норм, гарын авлага худалдан авах үнэ зэрэг ажил гүйцэтгэхэд шаардагдах зардал, ажлын хөлс, ажил гүйцэтгэгчийн олох орлого, ашиг, ажлын үр дүнг эрх бүхий байгууллагаар батлуулах зардал болон бусад холбогдох бүхий л зардал багтсан болно.
- 12.3. Ажил гүйцэтгэх хугацаанд Засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоосон болон Захиалагчаас үл шалтгаалах байдлаар ажлын өртөг нэмэгдэхтэй холбогдсон эрсдэлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

**13. Төлбөр тооцоо**

- 13.1. Захиалагч нь гэрээний 12.1-д заасан ажлын төлбөрийг дараах байдлаар шилжүүлнэ. Үүнд:

13.1.1. урьдчилгаа ажлын үнэ, хөлс-(гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор)-50 хувь,

13.1.2. ажлын үнэ, хөлс-(ажлын гүйцэтгэлийг актаар баталгаажуулан Захиалагчид хүлээлгэн өгсний дараа ажлын 3 хоногийн дотор)-40 хувь,

13.1.3. үлдэгдэл ажлын үнэ, хөлс –(тус зураг төслөөр үйлдвэрлэгдсэн хоолойг даацын туршилт хийж баталгаажуулснаар) – 10 хувь,

13.2. Захиалагч ажлын үнэ, хөлсийг нэхэмжлэлийн дагуу Гүйцэтгэгчийн Богд банк дахь 8120001132 тоот төгрөгийн дансанд шилжүүлгээр төлнө.

#### **14. Захиалагчийн эрх, үүрэг**

14.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;

14.2. Ажлын явцын тайланг Гүйцэтгэгчээс авах;

14.3. Гүйцэтгэгчийн гүйцэтгэж буй ажил, бусад дагалдах ажилд хяналт тавьж, цаг тухайд нь шалгах, шаардлага тавих, шаардлагатай гэж үзвэл ажлыг зогсоох,

14.4. Гүйцэтгэгч талын үйл ажиллагааны алдаа, зөрчлийн улмаас үүссэн аливаа хохирлыг нөхөн төлүүлэх, алдаа, зөрчлийг үнэ төлбөргүй дахин шинэчлүүлэх талаар шаардлага тавих;

14.5. Шаардлагатай тохиодолд ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн байгууллага, мэргэжилтнээр хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх эрхтэй.

14.6. Гэрээний хавсралт болох ажлын даалгавар болон бусад бичиг баримтыг хууль тогтоомж, стандарт, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, зааварт нийцүүлэн гаргах,

14.7. Захиалагч нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээний үнийг Гүйцэтгэгчид хугацаанд нь төлөх;

14.8. Ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд өөрсдийн зүгээс шаардлагатай туслалцааг Гүйцэтгэгч талд үзүүлэх;

14.9. Захиалагчийн зүгээс ажил хийж гүйцэтгэхтэй холбогдсон шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах,

14.10. Энэхүү гэрээ, хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

#### **15. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

15.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Захиалагчаас шаардах;

15.2. Гэрээний үнийг гэрээнд заасны дагуу хүлээн авах;

15.3. Захиалагч талаас гаргаж өгөх мэдээлэл, материалыг боломжит цаг хугацаанд нь шаардан авах;

15.4. Захиалагчтай ажлын тайлан, үр дүн, дүгнэлт дээр санал зөрөлдсөн тохиолдолд ажлын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт хийлгэх;

15.5. Гэрээнд заасан ажлыг хууль тогтоомж, стандарт болон журам, аргачлал, Захиалагчаас өгсөн ажлын даалгаврын дагуу гүйцэтгэн, хүлээлгэн өгөх;

15.6. Гүйцэтгэлийн үр дүнгийн үнэн зөв, доголдолгүй байдлыг бүрэн хариуцах;

15.7. Зураг төслийн дагуу барилгын ажил гүйцэтгэгдэх явцад зураг төсөл зохиогчийн

хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлэх ба Захиалагч, Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллана.

15.8. Ажлын гүйцэтгэлтэй холбогдсон алдаа, зөрчил, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгдээгүй, чанарын доголдолтой үр дүн гарсан тохиолдолд Захиалагчид хохирлыг барагдуулах, дахин үнэ төлбөргүйгээр засч өгөх;

15.9. Энэхүү гэрээ, хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

## **16. Нууцлал**

16.1. Гэрээ нь Талуудын нууцад хамаарах бөгөөд хууль болон гэрээнд зааснаас бусад тохиолдолд нөгөө Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээний талаарх аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

16.2. Хуульд заасны дагуу байгууллагын нууцтай танилцах эрх бүхий төрийн байгууллага, түүний албан тушаалтан энэ зүйлд заасан мэдээлэлтэй танилцахаар хүсэлт гаргасан, эсхүл шаардсан тохиолдолд талууд уг мэдээллийг хуульд заасан журмын дагуу танилцуулах бөгөөд энэ талаар нөгөө талдаа урьдчилан мэдэгдэнэ.

16.3. Талуудын аль нэг нь энэ зүйлд заасан үүргээ зөрчсөний улмаас нөгөө талын бизнесийн нэр хүндэд хохирол учирсан, материаллаг хохирол учруулсан бол буруутай тал нь түүнийг бүрэн хариуцна.

## **17. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

17.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

17.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө Талдаа саналаа бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, түүний төслийг тусгана.

17.3. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

## **18. Гэрээний зөрчлийг арилгах, гэрээ цуцлах**

18.1. Талууд гэрээг цуцлах саналтай байгаа бол уг саналаа нөгөө Талд бичгээр хүргүүлж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

18.2. Захиалагч нь дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

18.2.1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхдээ чанарын ноцтой доголдол гаргасан бөгөөд захиалагч ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн;

18.2.2. Гүйцэтгэгч нь ажлын доголдлыг боломжит хугацаанд арилгаагүй, эсхүл ийнхүү арилгахаас зайлсхийсэн;

18.2.3. Давагдашгүй хүчин зүйл 30 ба түүнээс олон хоног үргэлжилсэн бөгөөд ажлыг үргэлжлүүлэх шаардлагагүй гэж үзсэн;

18.2.4. Гүйцэтгэгч хуурамч баталгаа бусад бичиг баримтыг гаргаж өгсөн;

18.2.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

18.3. Гүйцэтгэгч дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

18.3.1. Захиалагч төлбөрөө шилжүүлэх хугацааг 10 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн, цаашид боломжит хугацаанд шилжүүлэхгүй нь тодорхой болсон;

18.3.2. Захиалагч ажлын хамрах хүрээг өөрчилсөн нь энэхүү гэрээнд заасан ажлын хөлсийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгосон бөгөөд захиалагч нэмэлт санхүүжилтийг гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан;

18.3.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

18.4. Гэрээг цуцалсан тохиолдолд ийнхүү цуцалснаас хойш ажлын 5 хоногийн дотор гэрээ цуцалсан өдрөөр тасалбар болгон Захиалагч гуравдагч ажил гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлэх эрхтэй. Хэрэв гүйцэтгэгчийн зохих ёсоор гүйцэтгээгүй ажлыг гуравдагч ажил гүйцэтгэгч үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой тохиолдолд тухайн ажилд ногдох Гүйцэтгэгчийн зардлыг захиалагч төлөх тохиолдолд гуравдагч ажил гүйцэтгэгчтэй зөвшилцсөнийг үндэслэн тооцно.

18.5. Гэрээний 18.1 -т заасны дагуу аль нэг Талын санаачилгаар Гэрээг цуцалсан бол буруутай Тал ийнхүү цуцалсантай холбоотой зардал болон нөгөө Талд учирсан хохирлыг нөхөн төлнө.

## **19. Хариуцлага**

19.1. Гүйцэтгэгч нь гэрээний 7.1-д зааснаар төмөр бетон угсармал хоолойн нэг маягийн зураг төсөл боловсруулах ажлыг 10 хоногт, бэлэн болсон зураг төслийг эрх бүхий байгууллагаар баталгаажуулж, Захиалагчид хүлээлгэн өгөх ажлыг 14 хоногийн дотор тус тус гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

19.2. Энэ гэрээний 18.2-д заасны дагуу гэрээг захиалагчийн санаачлагаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний торгууль хүлээх бөгөөд захиалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.

19.3. Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.

19.4. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нөгөө талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнө.

19.5. Хэрэв аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол энэ нь эрхээсээ татгалзсан гэж тооцохгүй бөгөөд эрхээ хожим хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахад саад болохгүй.

19.6. Аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас зохих ёсоор биелүүлээгүй болох нь нотлогдвол үүрэг давагдашгүй хүчин зүйлийг арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Захиалагч төрийн эрх бүхий байгууллагаас хамааралтайгаар гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд саад учирсан тохиолдолд Захиалагчийн үүрэг тухайн нөхцөлийг арилах хүртэл хугацаагаар хойшилно.

## **20. Маргаан шийдвэрлэх**

20.1. Талууд харилцан хүндэтгэлтэй, бизнесийн ёс зүйг чанд сахиж, гэрээтэй холбоотой аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.

20.2. Энэхүү гэрээг тайлбарлах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

20.3. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 21. Гэрээний хавсралт

21.1. Энэхүү гэрээнд дараах хавсралтуудыг хавсаргана. Үүнд:

21.1.1. Хавсралт №1 Ажлын даалгавар

21.1.1. Хавсралт №2 Ажлын төсвийн тооцоо

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ийн  
Инженер технологийн хэлтсийн дарга

 Д.НЯМЛХАГВА

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ПИ СИ ДИ ПИ” ХХК-ийн Зам  
гүүрийн албаны дарга



Г.БАЯРМӨНХ

“ПИ СИ ДИ ПИ” ХХК-ийн Гэрээний  
мэргэжилтэн

 Б.ЦЭНДМАА



АТТ-19/267236/101




**ХООЛОЙН НЭГ МАЯГИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**


Д.Д.	Зураг төсөлд тавигдах шаардлага	Өгөгдөл болон Тусгайлсан Даалгавар
1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	
2.	Зориулалт	Төмөр замын салбарт нэг маягийн угсармал төмөр-бетон хийц эдлэл үйлдвэрлэж, нийлүүлэх
3.	Угсармал төмөр-бетон хоолойны төрөл болон хэмжээс	1. Дугуй огтлолт: <ul style="list-style-type: none"> <li>▪ Ø1500 (мм);</li> <li>▪ Ханын зузаан:               <ul style="list-style-type: none"> <li>▪ <input type="checkbox"/> Тооцоогоор</li> </ul> </li> </ul> 2. Дөрвөлжин огтлолт: <ul style="list-style-type: none"> <li>▪ 1500x1500;</li> <li>▪ 2000x2000;</li> <li>▪ 3000x3000;</li> </ul>
4.	Мөрдөх норм болон стандарт	Дотоод БНБД 6229. 2010
5.	Хөдөлгөөнт ачаалал (Локомотив)	<ul style="list-style-type: none"> <li>▪ С14 (БНБД 32.02.11);</li> <li>▪ ТЕ33А (дизель локомотив);</li> <li>▪ Cooper Series Locomotive (250kN, 320kN, etc);</li> <li>▪ <input type="checkbox"/> Өөр бол тусгайлан заана;</li> </ul>
6.	Дугуй хоолойн дээрх шороон хучлаганы тооцоонд авах хамгийн их зузаан	<ul style="list-style-type: none"> <li>▪ <input type="checkbox"/> 6,0 (м) хүртэл;</li> <li>▪ <input type="checkbox"/> Өөр бол тусгайлан заана;</li> </ul>
7.	Дөрвөлжин хоолойн дээрх шороон хучлаганы тооцоонд авах хамгийн их зузаан	<ul style="list-style-type: none"> <li>▪ <input type="checkbox"/> 6.0 (м) хүртэл хүртэл;</li> <li>▪ <input type="checkbox"/> Өөр бол тусгайлан заана;</li> </ul>
8.	Хоолойны залгаасны төрөл	<ul style="list-style-type: none"> <li>▪ <input type="checkbox"/> Эр, эм углуургатай;</li> <li>▪ <input type="checkbox"/> Бусад;</li> </ul>
9.	Тусгай нөхцөл	Эрх бүхий байгууллагаар баталгаажуулах
10.	Зураг төслийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хийцийн тооцоо: 1%;</li> <li>▪ Зураг: АЗ эх хувь, хуулбар -3%, файл хэлбэрээр CD-нд буулгасан 1 %;</li> <li>▪ Товч техникийн шаардлага: эх хувь, хуулбар 3%, файл хэлбэрээр CD-нд буулгасан 1 %;</li> <li>▪ Хоолой тус бүр дээр 1 болон 2 метрийн урттайгаар төлөвлөсөн хэсэглэлийн зураг төсөл</li> <li>▪ Угсармал т/б хоолой үйлдвэрлэх төсөв:               <ul style="list-style-type: none"> <li>• Estimator төсвийн програмаар: А4, 1%</li> <li>• Зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн excel програмаар: А4, 1%</li> </ul> </li> </ul>

ХЯНАСАН: ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА: *[Signature]* /Д.НЯМЛХАГВА/

БОЛОВСРУУЛСАН: ХИЙМЭЛ БАЙГУУЛАМЖИЙН ИНЖЕНЕР: *[Signature]* /Э.МӨНХЗОЛБОО/



АГТ-19/267236/104 Хавсаралт 2




Төмөр Замын Угсармал Төмөр-Бетон Угсармал Хоолойн Их Биенийн Нэг Маягийн Зураг Төсөл Боловсруулах Зөвлөхийн Үйлчилгээ

Rev.00

Д.Д.	Зөвлөх Үйлчилгээний Ажлын Задаргаа	Хэмжих Нэгж	Тоо Хэмжээ	Нэгж Өртөг (₮)	Нийт Өртөг (₮)	Тайлбар
1	<b>Холбогдох ОУ -н болон Дотоодын Стандарт, БНБД -н тавигдах шаардлагуудыг судлах</b>					
1.1	Холбогдох төмөр замын дотоод & гадаад стандарт норм олж судлах	хүн*сар	0.125	3,450,000	431,250	1. Гүүрийн Инженер-1 2. Хийцийн Инженер - 1 3. Зургийн Инженер -4 4. Материалын Инженер-1 5. Тоо хэмжээ & төсөвчин -2
1.2	BS -н стандарт олж судлах	хүн*сар	0.0625	3,450,000	215,625	
1.3	ГОСТ -н стандарт олж судлах	хүн*сар	0.0625	3,450,000	215,625	
1.4	EN -н стандарт олж судлах	хүн*сар	0.0625	3,450,000	215,625	
1.5	MNS стандарт олж судлах	хүн*сар	0.0625	3,450,000	215,625	
1.6	БНБД олж судлах	хүн*сар	0.0625	3,450,000	215,625	
1.7	Бусад (ACI, ASTM & GB)	хүн*сар	0.0625	3,450,000	215,625	
1.8	Судалсан стандарт & нормын дагуу тавигдах шаардлагуудын талаар сургалт / танилцуулга хийх	хүн*сар	1	150,000	150,000	
1.9	Шаардлагатай стандарт & Норм худалдаж авах	иж бүрдэл	1	150,000	150,000	
	<b>Дүн [1]</b>				<b>2,025,000</b>	
2	<b>Тооцоо &amp; Зургийн Ажил</b>					
2.1	Захиалагч талаас өгсөн даалгаварын дагуу 4 төрлийн УТБ хавтангийн тооцоо хийх	хүн*сар	1	5,000,000	5,000,000	
2.2	УТБ хавтангийн доорх далангийн суурь бүтцийн уридчилсан тооцоо хийх, хавтан угсрахад тавигдах гол шаардлагуудыг ажлын зурагт нэмэлтээр оруулах	хүн*сар	1	3,450,000	3,450,000	
2.3	УТБ хавтангийн ажлын зураг боловсруулах	хүн*сар	1	3,450,000	3,450,000	
2.4	УТБ хавтангийн ажлын зурагт угсралтын гоцлоо & хүчитгэх тоноглолууд, залгаасны хэсэглэлүүдийг нарийвчлан тусгах	хүн*сар	0.25	3,450,000	862,500	
2.5	Бетон, арматур, заадасны тоноглолууд, хүчитгэлийн материал & тоноглолуудын тоо хэмжээг нарийвчлан бодож түүвэр гаргах	хүн*сар	0.5	3,450,000	1,725,000	
2.6	УТБ хавтангын төсөвийг 2 хувилбараар тооцож гаргах	хүн*сар	0.25	3,450,000	862,500	
2.7	Техникийн Товч Шаардлага боловсруулах	хүн*сар	0.25	3,450,000	862,500	
2.8						
	<b>Дүн [2]</b>				<b>16,212,500</b>	
	Дайвар & Ашиг (7.5%)	7.50%			1,367,813	
	<b>Бүгд Дүн [1+2]</b>				<b>17,580,313</b>	

Note: (i). Дээрх үнэнд НӨАТ ороогүй болно (ii). Дээрх ажлыг 10 хоногийн хугацаанд хийхээр төлөвлөсөн болно. (iii). УТБ - Угсармал Т/Б Хавтан -г товчилсон үг болно. (iv). Шаардагдах стандарт, норм & гарын авлагыг худалдан авах үнэ орсон

Боловсруулсан: *Цэндмаа* Б Цэндмаа (PCDP)  
Хянасан: *Баярмөнх* Г Баярмөнх (PCDP)  
Танилцсан: *Пунцагноров* Пунцагноров (PCDP)





“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ”  
ТӨХК-д

Пи Си Ди Пи ХХК  
Монгол улс, Улаанбаатар 14230  
Сүхбаатар дүүрэг, Нарны зам 91,  
Санроуд билдинг 5 давхар  
Утас: +976 7711 7196 Факс: +976 7711 7195  
Цахим шуудан: info@pcdp.mn

2019.10.01 № 224/19

танай \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ -т

Г Үнийн санал хүргүүлэх тухай Г

“Монголын Төмөр зам” ТӨХК-иас санал тавьсны дагуу Пи Си Ди Пи ХХК нь “1,5 метр дугуй хоолой, 1,5 x 1,5 метр дөрвөлжин хоолой, 2 x 2 метр дөрвөлжин хоолой, 3 x 3 метрийн дөрвөлжин хоолой, нэг маягийн иж бүрэн зураг төсөл боловсруулах” ажлын Үнийн саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Бидний саналыг судлан үзэж хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ч.МАРАЛМАА ✓

*ИТХ-ийн төсөв  
доор 2 компанитайс  
ийний санал өгч  
дөрвөлжин хоолой  
яарайтай төсөв.  
Амармаа  
2/01.*